



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээ тогтоосон жагсаалтын 42-т “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн 17,247.70 сая төгрөгийг төлөх хугацааг 2023 оны 3 дугаар улирал хүртэл хойшлуулсугай.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээ тогтоосон жагсаалтын 33-т “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ногдол ашгийн хэмжээг 1,529.25 сая төгрөг гэснийг 498.20 сая төгрөг болгон өөрчлөн шинэчлэн тогтоосугай.

3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Ашигт малтмалын ордны тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хэмжээ тогтоосон жагсаалтын 4-т “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 47,184.20 сая төгрөгийг төлөх хугацааг 2023 оны 3 дугаар улирал хүртэл хойшлуулсугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132003461

26-r_huraldaan.docx